



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

### ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“4.Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журмын төслийг Нийслэлийн Засаг даргын Захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д. Мөнх-Эрдэнэ танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дугаар зүйлийн 10<sup>1</sup>.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журмын төслийг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх (Д. Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгов” гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1110200326